

# ТООН ГАРЫН ҮСГИЙН ГЭРЧИЛГЭЭ ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Хэрэглэгчийн төрөл : Албан байгууллага  
Гэрчилгээний хугацаа:  1 жил  
 2 жил

## БАЙГУУЛЛАГЫН СЕРТИФИКАТ ЭЗЭМШИГЧИЙН

Ургийн овог :   
Овог :   
Нэр :   
РД :   
Хүйс :  Эр  Эм  
Утас :   
И-мэйл хаяг :

## БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Улс/Хот :   
Байгууллагын РД :   
Байгууллагын нэр :   
Газар/ Хэлтэс/ Алба :   
Албан тушаал :   
Хаяг :   
Утас :   
Албан тушаалтны  
И-мэйл хаяг :   
Вэбсайт :

Мэдээллийг үнэн зөв бөглөсөн: /...../

Огноо: \_\_\_\_ он \_\_\_\_ сар \_\_\_\_ өдөр

Бүртгэлийн ажилтан :

## ТООН ГАРЫН ҮСГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ГЭРЭЭ /БАЙГУУЛЛАГА/

ЭНЭХҮҮ ХЭРЭГЛЭГЧИЙН ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ НЬ “ТРИДУМ”-ЫН ЗҮГЭЭС ТООН ГАРЫН ҮСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХДЭЭ ТАНД ТАВЬЖ БҮЙ НӨХЦӨЛ ШААРДЛАГЫГ ТУСГАСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ ЮМ. ИЙМД ТА ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛТЭЙ САЙТАР ТАНИЛЦАН ГАРЫН ҮСЭГ ЗУРЖ, БАТАЛГААЖУУЛНА УУ.

### 1. ТЭЭГЧ ТӨХӨӨРӨМЖ, ТҮҮНИЙ НӨХЦӨЛ

- 1.1 Тээгч төхөөрөмж гэдэг нь тоон гарын үсгийг агуулж буй хадгалах төхөөрөмж юм.
- 1.2 Тээгч төхөөрөмж нь PIN буюу нэвтрэх, баталгаажуулах нууц үг, SO PIN буюу нэвтрэх, баталгаажуулах нууц үгийг сэргээх нууц үг гэсэн 2 төрлийн нууц үгтэй байна.
- 1.3 Тээгч төхөөрөмжийн нууц үгийг 10 удаа буруу оруулсан тохиолдолд төхөөрөмж түгжигдэх ба SO PIN нууц үгийг зөв оруулснаар түгжээг тайлах боломжтой.
- 1.4 Тээгч төхөөрөмжийн SO PIN нууц үгийг 10 удаа буруу оруулсан тохиолдолд гэрчилгээ хүчингүй болох ба төхөөрөмжийг форматалснаар дахин шинээр гэрчилгээ суулгах боломжтой.

### 2. ТООН ГАРЫН ҮСГИЙН ГЭРЧИЛГЭЭ, ТҮҮНИЙ НӨХЦӨЛ

- 2.1 Тоон гарын үсэг гэдэг нь Цахим гарын үсгийн тухай хуулийн 6.2-т заасан шаардлагыг хангасан цахим гарын үсгийг хэлнэ.
- 2.2 Тоон гарын үсгийн гэрчилгээ шинээр худалдан авахдаа гэрчилгээжүүлэгч байгууллага, бүртгэлийн нэгжийн шаардлагын дагуу баримт бичгийн бүрдүүлбэрийг бүрдүүлж, 1 болон 2 жилийн хугацаатай үүсгүүлнэ.
- 2.3 Тээгч төхөөрөмжийн SO PIN нууц үгийг 10 удаа буруу оруулж тээгч төхөөрөмж түгжигдсэн тохиолдолд гэрчилгээг сэргээх боломжгүй ба эзэмшигч гэрчилгээг шинээр худалдан авна.

### 3. ТА ТООН ГАРЫН ҮСГИЙН ЭЗЭМШИГЧ БОЛСНООР ДАРААХ ҮҮРЭГ ХҮЛЭЭНЭ

- 3.1 Хувийн түлхүүрийн тээгч төхөөрөмжийн нэвтрэх, баталгаажуулах нууц үг (PIN) болон SO PIN нууц үгийг мартахагүй, санаж байх;
- 3.2 Хувийн түлхүүрийн тээгч төхөөрөмжийн нэвтрэх, баталгаажуулах нууц үг (PIN), SO PIN нууц үгийг бусдаас нууцлах;
- 3.3 Хувийн түлхүүрийн тээгч төхөөрөмжийг бусдад дамжуулахгүй байх;
- 3.4 Хувийн түлхүүрийн нууцлалыг найдвартай хадгалах;
- 3.5 Хувийн түлхүүрийн нууц үгийг бусад этгээд мэдсэн, эсвэл мэдэх үндэслэлтэй гэж үзсэн бол хувийн түлхүүрийн нууц үгийг нэн даруй солих;
- 3.6 Хувийн түлхүүр тээгч төхөөрөмжийг алдсан гэж үзсэн бол энэ тухай гэрчилгээ олгогч байгууллагын бүртгэлийн нэгж болох Тридумын 70120722 утсанд болон [info@tridumkey.mn](mailto:info@tridumkey.mn) имэйл хаягт нэн даруй мэдэгдэж түр түдгэлзүүлэх;

### 4. ГЭРЧИЛГЭЭГ СЭРГЭЭХ

- 4.1 Хүчингүй болсон гэрчилгээг сэргээх боломжгүй.
- 4.2 Гэрчилгээний хугацаа дууссан эсвэл хүчингүй болсон тохиолдолд дахин шинээр худалдан авах хүсэлт илгээнэ.
- 4.3 Түдгэлзүүлсэн гэрчилгээг сэргээхдээ гэрчилгээ эзэмшигчийн болон ажил олгогч байгууллагын бичгээр гаргасан хүсэлтийн дагуу сэргээнэ.

### 5. ГЭРЧИЛГЭЭГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ

- 5.1 Гэрчилгээг түр хугацаанд түдгэлзүүлэхдээ Тридумын 70120722 утсанд болон [info@tridumkey.mn](mailto:info@tridumkey.mn) имэйл хаягт эсвэл бүртгэлийн нэгж дээр очиж бүртгэлийн ажилтны асуумжинд хариулснаар түдгэлзүүлэх боломжтой.

- 5.2 Гэрчилгээг түдгэлзүүлсэн хугацаа нь гэрчилгээний гэрээний хугацаанд тооцогдоно.
- 5.3 Гэрчилгээ эзэмшигчийн эсхүл ажил олгогч байгууллагын бичгээр гаргасан хүсэлтийн дагуу гэрчилгээг хүчингүй болгоно.
- 5.4 Гэрчилгээ эзэмшигчийн овог нэр, регистрийн дугаар, имэйл, албан тушаал, ажлын байр болон ажлын байрны нэр, байгууллагын регистрийн дугаар, газар, хэлтэс, алба өөрчлөгдсөн тохиолдолд гэрчилгээг хүчингүй болгоно.
- 5.5 Дараах тохиолдолд гэрчилгээг хүчингүйд тооцно.
  - 5.5.1 Гэрчилгээний хугацаа дуусгавар болсон.
  - 5.5.2 Гэрчилгээ эзэмшигч иргэн нас барсан.
  - 5.5.3 Гэрчилгээ эзэмшигч байгууллага татан буугдсан.
  - 5.5.4 Гэрчилгээг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон.
  - 5.5.5 Гэрчилгээ эзэмшигч гэрээний нөхцөлд заасан үүргээ биелүүлээгүй.

### 6. ГЭРЧИЛГЭЭГ СУНГАХ

- 6.1 Хугацаа нь дууссан гэрчилгээг сунгаж, дахин ашиглах боломжгүй ба шинээр баримт бичгийг бүрдүүлэн худалдан авах боломжтой.
- 6.2 Гэрчилгээний хугацаа дуусахаас өмнө гэрчилгээг сунгаж болно.
- 6.3 Гэрчилгээг бүртгэлийн нэгж дээр биеэр очих эсвэл онлайн системээр сунгуулна.

### 7. ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ

- 7.1 Гэрчилгээ эзэмшигч өөрийн буруугаас болж хувийн түлхүүрийг алдсан, хувийн түлхүүрийн нууцыг задалсан, PIN болон SO PIN нууц үгийг мартсанаас үүдэх үр дагаврыг эзэмшигч тал өөрөө хүлээнэ.
- 7.2 Энэхүү гэрээний нөхцөлийн 5.4-д заасны дагуу гэрчилгээ эзэмшигч, ажил олгогч байгууллага Тридумд нэн даруй мэдэгдэж, гэрчилгээг хүчингүй болгуулаагүйгээс үүдэн гарах аливаа хохирлыг гэрчилгээ олгогч байгууллага, бүртгэлийн нэгж хариуцахгүй.
- 7.3 Үүсгэсэн гэрчилгээний мэдээллийг засах, солих боломжгүй ба гэрчилгээ эзэмшигчийн мэдээлэл солигдсон, гэрчилгээний мэдээллийг буруу өгч үүсгүүлсэн зэрэг гэрчилгээжүүлэгч байгууллагад үл хамаарах шалтгааны улмаас гэрчилгээг дахин шинээр үүсгүүлэх тохиолдолд гэрчилгээг шинээр худалдан авч үүсгүүлнэ.
- 7.4 Үйлдвэрийн гэмтэлтэй /Nonfunctioning, factory damaged/ бус хэрэглэгч талын буруутай ашиглалтын улмаас тоон гарын үсгийн төхөөрөмж гэмтэж, тоон гарын үсгийн гэрчилгээг ашиглах боломжгүй болсон тохиолдолд төхөөрөмж, гэрчилгээг дахин шинээр худалдан авч ашиглана.
- 7.5 Итгэмжлэлээр олгосон гарын үсгийг хууль бусаар ашигласнаас үүдэх хариуцлагыг итгэмжлэгч тал өөрөө хүлээнэ.

Гэрчилгээ эзэмшигчийн гарын үсэг:

/...../

Бүртгэлийн ажилтны гарын үсэг:

/...../

Огноо:

/...../